



**Монгол улсын ашигт малтмалын тухай
хуулийн шинэчилсэн төслийн эдийн
засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ**

Доктор Брайн Фишер

**Монголын Бизнесийн Зөвлөл
3-р сарын 18, Кемпински Зочид буудал, Улаанбаатар хот**

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн төслийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ



Судалгааны ажлын зорилго, агуулга

Судалгааны зорилго: Энэхүү судалгааны ажлын зорилго нь “Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн төслийн Монгол улсын эдийн засагт үзүүлэх шууд болон шууд бус нөлөөлөл”-ийг үнэлэхэд оршино

Агуулга:


- 1 • Уул уурхайн секторын Монголын эдийн засагт гүйцэтгэх үүрэг
- 2 • Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн төсөл
- 3 • Судалгааны арга зүй, үндсэн таамаглал
- 4 • Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн төслийн эдийн засагт үзүүлэх нөлөөлөл (судалгааны үр дүн)
- 5 • Дүгнэлт

Уул уурхайн секторын Монголын эдийн засагт гүйцэтгэх үүрэг

Дэлхийн санхүү, эдийн засгийн хямарлаас хойш уул уурхайн салбар нь Монголын эдийн засгийн өсөлтийн тайлбарлагч гол хүч болж байна

Уул уурхайн секторын Монголын эдийн засаг, экспортод үзүүлж буй нөлөө

Нэрлэсэн ДНБ



Экспорт




Өнгөрсөн 4 жилийн хугацаанд, уул уурхайн секторын үйлдвэрлэл нь нийт ДНБ-ий дунджаар ¼-г бүрдүүлж байсан бөгөөд Таван Толгой, Оюу Толгой төслүүд бүрэн хүчин чадлаараа ажиллах үед эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам өсөх болно. Уул уурхайн салбарын ДНБ-д эзлэх хувь нь тус секторын эдийн засагт гүйцэтгэх үүргийг бүрэн илэрхийлэхгүй. 2011 оноос уул уурхайн салбар дангаараа нийт экспортын 90 орчим хувийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнээс нүүрс, зэс, алтны экспорт нь нийт экспортын 80 орчим хувийг бүрдүүлж байна.

Ашигт малтмалын эрэлтийн өсөлт болоод бизнесийн явуулах таатай нөхцөл нь Монгол улсад гадаад шууд хөрөнгө оруулалтыг татах гол нөхцөл болж байна




Уул уурхайн секторын гадаад хөрөнгө оруулалтад үзүүлж буй нөлөөлөл

Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Уул уурхайн салбар дахь гол хөрөнгө оруулалтууд



Сүүлийн 4 жилд, нийт ГШХО-ын 81% нь буюу 8.6 тэрбум доллар дангаараа уул уурхайн салбарт орсон. Үүнээс Оюу Толгойн төслөөс эхний шатны бүтээн байгуулалтын хүрээнд 6.2 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг хийсэн. 2012 оны байдлаар томоохон нүүрсний уурхайнуудын нэг Ухаа Худаг (Монголын Уул Уурхайн Корпораци) нийтдээ 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг бонд болон IPO хийх замаар босгон, дэд бүтцэд хөрөнгө оруулалтад зарцуулж байна

Хурдтай өсч буй уул уурхайн сектороос орж буй орлого нь улсын төсвийн санхүүжилтийн чухал эх үүсвэр болж байна

Уул уурхайн секторын улсын төсөвт үзүүлж буй нөлөөлөл

Уул уурхайн салбар дахь гол татварууд




Нэгдсэн төсвийн орлого (₮, их наяд)




Уул уурхайгаас орох татварын болоод татварын бус орлого нь сүүлийн жилүүдэд хурдтай өссөөр байна. Сүүлийн 4 жилийн хугацаанд улсын төсөвт уул уурхайн салбараас 4.2 их наяд төгрөгийг татвараар, 0.75 их наяд төгрөгийг урьдчилгаа төлбөр хэлбэрээр төвлөрүүлэв. Дан ганц уул уурхайн компаниудаас төлөх шууд татвар бус мөн тэдгээрийг дагасан үйлчилгээний компаниудаас төвлөрүүлэх татварын хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, сүүлийн 3 жилд Оюу Толгой төслөөс дотоодын ханган нийлүүлэгчиддээ нийт 283.9 тэрбум төгрөгийн татвар (НӨТ) төлсөн байна.

Цаашид бизнесийн орчин таатай нөхцөлд тодорхой тооны уул уурхайн төслүүд үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байна

Стратегийн ач холбогдолтой нөөцүүд



Төслүүдийн тоо



Бизнесийн орчин таатай байх нөхцөлд ирэх 3 жилд 9 ширхэг шинэ уул уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд ихэнх нь нүүрсний төсөл юм. Эдгээр төслүүдийн хүлээгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь 2015 он гэхэд 6.3 тэрбум ам.долларт хүрэх юм.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

Хэдийгээр ашигт малтмалын тухай хууль нь уул уурхайн салбарыг зохицуулагч гол хууль боловч, бусад олон хуулиуд мөн уг салбарт нөлөөлдөг



Уул уурхайн төслүүдэд хамааралтай хуулиуд



^Хөдөлмөрийн хүчийг гаднаас авах, гадагшаа гаргах

*Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын Хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал Хайх, ашиглахыг хориглох тухай

Гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд хөрөнгө оруулалтын орчинг тогтвортой байлгах шаардлагатай



BAEconomics

- Тухайн орны гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах хүч нь дотоод зах зээл дээрх хөрөнгө оруулалтын орчин, тогтвортой бодлогын дэглэм болоод бусад хөрөнгө оруулалтын боломжуудтай харьцуулахад өрсөлдөхүйц хэмжээний татварын хувь хэмжээ зэргээс тус тус хамаардаг.
- Татвар хувь хэмжээ болоод бусад бодлогын арга хэмжээ нь тодорхой бус, нэгэнт байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээнд дахин хэлэлцээр хийх дарамт өндөртэй орнууд нь бусад татварын болоод бодлогын хувьд тогтвортой, хөрөнгө оруулалтын гэрээ бүрэн хүндэтгэн үздэг орнуудтай харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалтыг татах тал дээр муу байдаг.

Шинэ ашигт малтмалын тухай хуулийн төслийн хайгуулын компаниудад үзүүлэх сөрөг нөлөөлөл нь өндөр байна

Уул уурхайн төслүүдэд хамааралтай хуулиуд

Уул уурхай компаниудын төрөл

Оюу Толгой, Таван толгой, Эрдэнэт гэх мэт том төслүүд

Дунд болон жижиг төслүүд

Хайгуулын компаниуд

Хуулийн төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүд

- Илүү өндөр эзэмшлийн хэмжээг шаардах (50% хүртэл байсан бол 75% хүртэл болсон)
- Бодит бусаар орон нутгийн оролцоог шаардах - 60% хүртэл худалдан авалтыг орон нутгийн аж үйлдвэрээс авах болон орон нутгаас лиценз эзэмшигч нь хамтын болон бусад гэрээг байгуулах шаардлагууд нь хэрэгжүүлэхэд бодит бус ба хүндрэлтэй
- Байгалийн нөөц баялгийг сорчлон олборлохыг хориглох (ордыг эдийн засгийн үр ашгаас үл хамааран бүхэлд нь олборлохыг шаардах)
- Хөрөнгө оруулах санхүүгийн сонирхолыг бууруулах (орд ашиглах гэрээг зөвхөн стратегийн ордуудад л байгуулах боломжтой, хаалтын үйл ажиллагааны зардлыг ажил гүйцэтгэх зөвшөөрөл авахын өмнө мөнгөн хэлбэрээр тусгай санд байршуулах шаардлага- капитал урсгалыг хаах)
- Хөрөнгө оруулагчдад эзэмшлийн баталгааг сулруулах (Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын лиценз эзэмшигч хувьцааны тодорхой хувийг төр үнэ төлбөргүй эзэмших эрхтэй)
- Хайгуулын зардлын хамгийн доод хэмжээг маш өндөр байлгах аар шаардах (US\$100 000)
- Лиценз олгох ил тод байдал сулрах (Тендерийг буцаах, зогсоосон тохиолдолд, 4 хүртэлх жилээр тендерт орсон газрын лицензийг дахин олгохгүй)

Хэдийгээр ирээдүйд уул уурхай салбар өсөх боломжтой ч, шинэ хуулийн төслийн хэрэгжилт, байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээг хүндэтгэн үзэхгүй байх зэрэг нь цаашид орох хөрөнгө оруулалт орох боломжийг хязгаарлана



Шинэ хуулийн төслийн уул уурхайн компаниудад үзүүлэх болзошгүй үр нөлөө

	Нөлөөлөл	Үр дүн
1 ОТ, ТТ, Эрдэнэт гэх мэт том төслүүд	<ul style="list-style-type: none">Илүү өндөр эзэмшлийн хэмжээг шаардахБодит бус орон нутгийн оролцоог шаардах - 60% хүртлэх худалдан авалтыг орон нутгийн аж үйлдвэрээс авах болон орон нутгийн хамтын гэрээг зайлшгүй байгуулах	<ul style="list-style-type: none">Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах (Оюу толгойн далд уурхай болон ТТ-н баруун цанхид хийх хөрөнгө олдохгүй)Илүү хүнд сурталтай болохЗардал өсөх
2 Дунд болон жижиг төслүүд	<ul style="list-style-type: none">Байгалийн нөөц баялгийг сорчлон олборлохыг хориглохХөрөнгө оруулах санхүүгийн сонирхолыг бууруулахХөрөнгө оруулагчдад эзэмшлийн баталгааг багасгах	<ul style="list-style-type: none">Гадаадын зах зээл дээр бүртгэлтэй дотоод компаниудын хөрөнгө оруулалт эрс буурах (үйлдвэрлэл нэмэгдэхгүй)Дотоод компаниудад нэмэлт хөрөнгө оруулалт хийгдэхгүй (үйлдвэрлэл нэмэгдэхгүй)Шинэ төслүүд хэрэгжихгүй
3 Хайгуулын компаниуд	<ul style="list-style-type: none">Хайгуулын зардлын хамгийн доод хэмжээг маш өндөр байлгахЛиценз олгох ил тод байдал сулрах	<ul style="list-style-type: none">Хайгуулын үйл ажиллагаа нэмэгдэхгүйЖижиг дунд хайгуулын компаниуд үйл ажиллагаагаа зогсооно

**Ашигт малтмалын тухай
хуулийн шинэчилсэн төслийн
эдийн засагт үзүүлэх
нөлөөллийн үнэлгээний
аргазүй, үндсэн таамаглал**

MINCGEMv2: Эдийн загийн салбарууд, засгийн газрын тооцоо бүхий динамик ерөнхий тэнцвэрийн загвар



Судалгааны арга зүй

Өгөгдлийн сан: GTAP8 (MINCGEMv2)

GTAP8 өгөгдлийн сан нь 2007 онд суурилсан бодит өгөгдлүүдтэй бөгөөд дэлхийн 129 улс/бүс, 57 бүтээгдэхүүний бүлгээс бүрдэнэ

MINCGEMv2 хувилбар нь бүтээгдэхүүний тоог 71 болгон өргөжүүлж, улсуудыг 10 бүлэгт (Монгол, Хятад, Орос, Энэтхэг гм*...), бүтээгдэхүүнүүдийг 20 бүлэгт нэгтгэсэн

- Уул уурхай (хүрэн нүүрс, коксчих нүүрс, зэс, алт, газрын тос, газ, кок, түлш болон бусад ашигт малтмалууд)
- Хөдөө аж ахуй (газар тариалан, мал аж ахуй, загас, ой аж ахуй)
- Боловсруулах үйлдвэрлэл (Хүнс, боловсруулсан зэс болон бусад үйлдвэрлэл)
- Цахилгаан эрчим хүч
- Тээвэр
- Барилга
- Төрийн удирдлага, Батлан хамгаалал, Эрүүл мэнд, Боловсрол
- Бусад үйлчилгээ

Аргазүй: Динамик CGE (Ерөнхий тэнцвэрийн тооцоолол)

BAEconomics нь олон эдийн засаг, олон секторуудтай динамик загварыг хөгжүүлсэн

Урт хугацааны эдийн засгийн төлөв байдлыг үнэлдэг. Алхам бүр нь нэг жилээр хийгддэг

Тухайн улсын үндэсний тооцооны матриц, эдийн засгийн нөхцөл байдал, болон бодлогын зохицуулалттай уялдуулан бүтээгдэхүүнүүдийн эрэлт тодорхойлогдоно

CGE загвар нь эрэлт нийлүүлтэд суурилсан загвар юм. Эдийн засгийн сектор бүр нь хүчин зүйл болон завсрын бүтээгдэхүүний хэрэглээ, нийлүүлэлтээр холбогдоно.

CGE нь эдийн засгийн нэг шокийн нөлөө бусад эдийн засгийн хувьсагчдадаа хэрхэн нөлөөлж, тухайн нэг хувьсагчийн шокт үзүүлэх хариу үйлдлийг загварчилдаг

Гол онцлог

CGE загвар нь эдийн засгийн гол адилтгал болон хязгаарлалтуудыг авч үздэгээрээ урт хугацааны төлвийг үнэлэхэд чухал үүрэгтэй:

- ДНБ-ий орлого ба зарлагын аргын тооцоо;
- Хөдөлмөр, хөрөнгө, байгалийн нөөцийн нийлүүлэлт;
- Зах зээл бүрийн тэнцвэр;
- Урсгал болон хөрөнгийн тэнцлийн харилцан хамаарал;
- Засгийн газрын зардал, татварын орлогын хамаарал;

Эдгээр нь үнэлгээний явцад тодорхойлогдоно.

CGE загвар нь тухайн нэг салбарын зардлын бүтэц болоод бүтээгдэхүүн хоорондын орлуулалт, эдийн засаг хоорондын өрсөлдөөний хэлбэр зэрэг 2 талт худалдааны мэдээллүүдийг нарийн авч үздэг.

CGE загвар нь хувилбарт бодлогын шинжилгээг хийхэд тохиромжтой шинж чанаруудыг агуулсан

RunDynam software: for recursive dynamic models



```
=====
TABLO CODE FOR MINCGEMv2

Raymond Mi
BAEconomics
11/09/2012
+++++!

!*****!
! MINCGEMv2.tab !
!*****!
! TABLO file for MINCGEM !
!*****!

!*****!
! FILES !
!*****!

FILE sets_file
# file with set specification #
;

FILE mbsam_file
# the major base data file #
;

FILE mbsam_p_file
# price and parameter data in previous mbsam.har #
;

FILE parsen_file
# file with some behavioral parameters (for sensitivity analyses) #
;

FILE mbpop_file
# file with population data #
;

FILE gov_file;

FILE(new) check_file;

!*****!
! SETS !
!*****!
```

Шинэчилсэн АМ-н хуулийн төслийн макро эдийн засгийн нөлөөллийг үнэлэхийн тулд MINCGEM-н хүрээнд дараах 2 хувилбарыг авч үзлээ

2 хувилбарт эдийн засгийн шинжилгээнд ашигласан таамаглалууд

	Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөөгүй хувилбар	Шинэ ашигт малтмалын тухай (АМ) хууль ба бодлогын тодорхойгүй байдалтай хувилбар
1 Уул уурхайн үйлвэрлэл	<ul style="list-style-type: none"> Одоо үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлолтын болон хайгуулын компаниуд ирээдүйд бүрэн хүчин чадлаараа ажилна 	<ul style="list-style-type: none"> Одоо үйл ажиллагаагаа явуулж компаниуд* үргэлжлүүлэн олборлолтоо явуулах боловч шинэ хайгуулын компаниудад үзүүлэх сөрөг нөлөө өндөр
2 Ашигт малтмалын үнэ	<ul style="list-style-type: none"> Ашигт малтмалын үнэ нь олон улсын байгууллагуудын дундаж таамаглал дээр суурилан, Монголын хил хүртэл үнээр засвардагдсан 	<ul style="list-style-type: none"> Ашигт малтмалын үнэ нь олон улсын байгууллагуудын дундаж таамаглал дээр суурилан, Монголын хил хүртэл үнээр засвардагдсан
3 Уул уурхайн ГШХО (хайгуулын & өргөтгөлийн)	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн нэмэлт хөрөнгө оруулалт Хүрэн нүүрс- US\$1.4 тэрбум Коксчих нүүрс- US\$1.2 тэрбум Зэс - US\$8.7 тэрбум 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн салбарт орох ГШХО-ын бууралтаас хамаарсан секторуудын өсөлтөд тулгуурлан загвараас тодорхойлогдоно (хөрөнгө оруулалтын эрэлтийн бууралт)
4 Дэд бүтцийн төслүүд	<ul style="list-style-type: none"> Төлөвлөгдсөн нэмэлт хөрөнгийг оруулалтыг загварт оруулснаар загвараас тодорхойлогдоно Нүүрс угаах байгууламж: <ul style="list-style-type: none"> Таван Толгой, ММСб Цахилгаан станц: <ul style="list-style-type: none"> Таван Толгой, Чандгана 	<ul style="list-style-type: none"> Уул уурхайн салбарт орох ГШХО-ын бууралтаас хамаарсан секторуудын өсөлтөд тулгуурлан загвараас тодорхойлогдоно (хөрөнгө оруулалтын эрэлтийн бууралт)

* - Оюу Толгойн ил уурхай


** -Таван Толгойн зүүн Цанхи

Шинэчилсэн АМ-н хуулийн төсөл хэрэгжилт нь ашигт малтмалын салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлнө




Таамаглал: Ашигт малтмалын үйлдвэрлэлийн хэмжээ (зэс ба нүүрс)


Одоогийн АМ хуультай хувилбар




Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус байдалтай хувилбар



Цэвэр зэс



Цэвэр зэс



*Коксчих нүүрс, хагас коксчих нүүрс, хүрэн нүүрс, угаасан нүүрс багтсан


2011 оноос өмнө хүрэн нүүрсийг зөвхөн дотооддоо хэрэглэдэг (цахилгаан, дулаан) байсан бол 2012 оны сүүлээс (11 сар) экспортод гаргах болсон




Үнийн таамаглал нь дэлхийн олон улсын байгууллагуудын дундаж үнийн төсөөлөлд суурилав

Таамаглал : Ашигт малтмалын үнийн олон улсын дундаж төсөөлөл (2013 оны үнээр)


Хүрэн нүүрс




Коксчих нүүрс



Цэвэр зэс



Алт




Загварт дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ Монголын хил дээрх үнэ хүртэл засварлагдсан

Загварын үр дүн

Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд эдийн засгийн өсөлт ирэх 20 жилд байх байсан түвшнээс дунджаар 4 нэгж хувиар бага байна

ДНБ-д үзүүлэх нөлөөлөл

Бодит ДНБ (их наяд ₮, 2013 оны үнээр)



ДНБ-н жилийн дундаж бодит өсөлт (%)




Шинэ АМ-н хууль, бодлогын тодорхой бус орчинд Монголын эдийн засгийн өсөлт ирэх 20 жилд (2013-2030) байх байсан түвшнээсээ дунджаар 4 нэгж хувиар (11% байхаас 7%) бага байхаар байна. Үнийн дүнгээрээ энэ зөрүү нь 358 их наяд төгрөг (2013 оны үнээр) буюу 2012 оны нийт ДНБ-ээс 23 дахин их юм

Шинэ АМ-н хууль, бодлогын тодорхой бус орчинд Монголын нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт ирэх 20 жилд байх байсан түвшнээсээ дунджаар 4 нэгж хувиар бага байна




Нэг хүнд ногдох ДНБ-д үзүүлэх нөлөөлөл

Нэг хүнд ногдох бодит ДНБ (сая ₮, 2013 оны үнээр)



Нэг хүнд ногдох бодит ДНБ-ий жилийн дундаж өсөлт (%)




Шинэ АМ-н хууль, бодлогын тодорхой бус орчинд Монголын эдийн засгийн дундаж өсөлт ирэх 20 жилд (2013-2030) байх байсан түвшнээсээ 4 нэгж хувиар (10% байхаас 6%) бага байхаар байна. Үнийн дүнгээрээ энэ зөрүү нь 106 сая төгрөг (2013 оны үнээр) буюу 2012 оны нэг хүнд ноогдох бодит ДНБ-ээс 19 дахин их юм.

Одоогийн АМ-ын хуулийн орчинд эдийн засгийн бүх салбарууд мэдэгдэхүйц өснө (хэдийгээр уул уурхайн салбараас ирэх хөдөлмөр, капиталын өрсөлдөөн хүчтэй ч)


Дотоод сектор

ДНБ, салбараар (их наяд ₮, 2013 оны үнээр)

Одоогийн АМ-ын хуультай хувилбар



Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинтой хувилбар




Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд уул уурхайн салбарын үйлдвэрлэл хамгийн багадаа 50%-аар буурахаар байна. Үүнийг дагаад бусад үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн гарц ч их хэмжээгээр буурна. Уул уурхайн салбарын бий болгож буй эерэг нөөц нь “Голланд өвчин”-ийн сөрөг нөлөөллөөс байна.

Шинэчилсэн АМ-н хуулийн төслийн Монгол улсын гадаад худалдаанд үзүүлэх нөлөө өндөр


Гадаад сектор

Гадаад худалдаанд үзүүлэх нөлөө (их наяд ₮, 2013 оны үнээр)

Экспортод үзүүлэх нөлөөлөл



Импортод үзүүлэх нөлөөлөл




Одоогийн хуулийн орчинд 2020 он гэхэд 12 их наяд төгрөгөөр их хэмжээний экспортыг болно. Тиймээс эдийн засгийн хурдтай өсөлт болон дотоод валютын ханшийн чангаралтаас шалтгаалан өрхүүдийн худалдан авалтын чадвар сайжруулж, улмаар импортын эрэлтийг өсгөнө

Шинэ АМ-н хуул, бодлогын тодорхой бус орчин нь богино хугацаанд дотоод валютын ханшийг сулруулж, өрхүүдийн худалдан авах чадварыг бууруулна


Гадаад сектор

Ханш болон худалдааны нөхцөлд үзүүлэх нөлөө (индекс, 2012=1)

Худалдааны нөхцөлд үзүүлэх нөлөөлөл



Валютын ханшид үзүүлэх нөлөөлөл




Одоо хэрэгжиж буй АМ-н хуулийн орчинд экспортын огцом өсөлт болон экспортын бүтээгдэхүүний үнийн тогтвортой өсөлтөөс шалтгаалан худалдааны нөхцөл сайжирна. Худалдааны нөхцлийн өсөлт нь 2020 оноос өмнөх бодит ханшийн чангаралтай шууд холбоотой. Мөн худалдааны нөхцөл сайжрах нь өрхүүдийн худалдан авах чадварыг өсгөхөөс гадна, хэрэглэгчдийн амьжиргааг нэмэгдүүлнэ.

ШинэАМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд хүмүүсийн бодит цалин буюу худалдан авах чадвар буурч, улмаар бодит хэрэглээг бууруулна


Өрхүүд

Бодит цалин болон хэрэглээнд үзүүлэх нөлөө (индекс, 2012=1)

Бодит цалинд үзүүлэх нөлөөлөл



Бодит хэрэглээнд үзүүлэх нөлөөлөл




2020 он гэхэд шинэчилсэн хуулийн төслийн нөлөөгөөр нийт бодит хэрэглээ 36%-аар буурахаар байна. Одоогийн хуулийн орчинд гадаад компаниудын импортлох технологи болоод дотоод ажилчдын дадлага, туршлагын өсөлт нь хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх бөгөөд улмаар бодит цалин өсөх гол шалтгаан болно. Харин 2020 он гэхэд шинэчилсэн хуулийн төслийн нөлөөгөөр, нийт бодит цалингийн хэмжээ 33%-р буурна.

Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчин нь засгийн газрын санхүүгийн байдлыг султган гадаад зах зээлээс хөрөнгө босгох боломжийг хязгаарлана


Засгийн газар

Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл (их наяд ₮, 2013 оны үнээр)

Уул уурайгаас цугларах татварын орлого



Нийт татварын орлого




Шинэ АМ-ын хуулийн хэрэгжилтээр засгийн газар уул уурхайн салбар төдийгүй бусад салбараас төвлөрүүлэх татварын хэмжээ буурна. Таамаглалын хугацаанд буюу 2013-2030 оны хооронд, шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд төсөвт уул уурхайн салбараас төвлөрүүлэх байсан 37 их наяд төгрөг (өнөөдрийн үнээр), харин нийт эдийн засгаас төвлөрүүлэх 110 их наяд төгрөгийн татварын орлогыг алдагдахаар байна. Тус тооцоонд ЗГ-ын уул уурхайн төслүүдээс авах ноогдол ашгийг оруулаагүй болохыг тэмдэглэх нь зүйтэй.

2017 болон 2022 онуудад хийгдэх Чингис бондыг эргэн төлөлтөд шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд алдах төсвийн орлогын алдагдал сөргөөр нөлөөлнө

Засгийн газар

Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл (их наяд ₮, 2013 оны үнээр)

Шинэчилсэн хуулийн төслөөр алдаж болох татварын орлогын хэмжээ




Монгол улсын Засгийн газар 2012 оны 11-р сард 1.5 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах дээрээс дотоод эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор босгосон. Шинэ АМ-н хууль, бодлогын тодорхой бус орчинд засгийн газрын зардал өөрчлөгдөхгүй (орлогоо дагаж танагдахгүй) гэж үзвэл, төсвийн орлогын алдагдлын хэмжээ 2017 гэхэд 1.5 тэрбум доллар, 2022 он гэхэд 13.5 тэрбум долларт хүрэхээр байна

Ашигт малтмалын тухай шинэ хуулийн төслийн Монгол улсад үзүүлэх сөрөг нөлөө өндөр

Дүгнэлт

Шинэ АМ-ын хууль, бодлогын тодорхой бус орчинд:

- Одоогийн мөрдөгдөж буй хуулийн орчинтой харьцуулахад ДНБ-ийн дундаж өсөлт 2013-2030 онуудын хооронд 4 нэгж хувиар бага байна (7%-с 11%)
- Эдийн засгийн салбаруудын хэмжээ одоогийн хууль хэвээр үлдэх үеийнхээс мэдэгдэхүйц бага болно. Учир нь уул уурхайн салбарын өндөр өсөлт нь бусад салбарууддаа үзүүлэх нөлөө нь өндөр.
- 2020-2030 оны хооронд нийт экспортын хэмжээ одоогийн хууль хэвээр үлдэх хувилбараас 60%-аар бага байна. Нийт импорт болон гадаад худалдааны салбарынханд мөн адил сөрөг нөлөөллийг үзүүлэх болно.
- 2030 он гэхэд шинэ хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд, өрхийн бодит хэрэглээ одоогийн хуулийн орчиноос 30%-аар буурна. Харин дундаж бодит цалин 35%-аар бага байна.
- Гадаадын дэвшилтэт технологийг эзэмших боломж хязгаарлагдмал болсноор дотоодын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт удааширна. Технологи шилжилт болоод “Хийхийн хирээр дадлагажих” зэрэг зарчмууд нь Зүүн азийн орнуудын эдийн засгийн хурдацтай өсөлтийн гол хүчин зүйлс байсан.
- Загварын таамаглалын хугацаанд буюу 2013-2030 онуудын хооронд Засгийн газар одоогийн хууль хэрэгжих үеийнхээс даруй 37 их наяд төгрөгийн орлогыг уул уурхайн салбараас, нийтдээ 110 их наяд төгрөгийн төсвийн орлогыг алдана.




Хавсралт

Дэлхийн санхүүгийн хямрал (ДСХ)-аас хойш Монголын эдийн засаг уул уурхай болон үйлчилгээний салбарт тулгуурлан эрчимтэйгээр өссөн


Дотоод сектор

ДНБ-нд уул уурхайн салбарын үзүүлэх нөлөө

Бодит ДНБ (их наяд төгрөг, 2010 оны үнээр)



Бодит ДНБ өсөлт (% , жилийн)



2010 оноос өмнө Эрдэнтийн Уулын баяжуулах үйлдвэр уул уурхайн гол үйлдвэрлэгч байсан. 2010 оноос хойш МАК, МАК Чинхуа, SGS –н Овоот толгой, жижиг ТТ, ТТ (зүүн цанхи) Ухаа худаг зэрэг томоохон уурхайнуудын нүүрсний экспорт эрс нэмэгдсэн. Уул уурхайн салбарын үйлчилгээ[^], барилга^{^^} болон гадаад салбарт^{^^^} үзүүлэх нөлөөл нь өндөр бөгөөд үүнийн үр дүнд татварын орлого ч нэмэгдсэн.

*Цэвэр татварт НӨТ, архи тамхинаас авах онцгой татвар болон гадаад худалдаанаас авах татвар багтсан болно.

[^]Шууд нөлөөлөл: уул уурхайн компаниудын нийлүүлэгч нар. Шууд бус нөлөөлөл: ихэнх хэрэглээ гаднаас дотогш мөнгөний урсгалаар (уул уурхайн экспорт ба хөрөөнгө оруулалт) дамжин үйлчилгээний салбараар ордог (бөөний болон жижиглэнгийн худалдаа дийлэнх хувийг эзэлнэ)

^{^^^}Уул уурхайн салбар нийт экспортын 90% оuzzлдэг ба уул уурхайн машин тоног төхөөрөмжийн нийт импортод эзлэх хувь өндөр.


Хэдийгээр уул уурхайн салбарын экспортын орлогын ихэнхийг бүрдүүлдэг ч дотоодын зах зээлээс шатахуун, эрчим хүч ба машин тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүнийг нийлүүлэх боломжгүйгээс импортод эзлэх хувь нь ч мөн өндөр




Гадаад салбар

Уул уурхайн гадаад худалдаанд үзүүлэх нөлөө

Экспорт (тэрбум доллар)



Импорт (тэрбум доллар)



Уул уурхайн салбар нь нийт экспортын дийлэнх хувийг бүрдүүлдэг. Нийт уул уурхайн экспортын 80 орчим хувийг нүүрс, зэс, алт эзэлдэг байна. Уул уурхайтай холбоотой импорт (ихэвчлэн уул уурхайн машин, тоног төхөөрөмж, эрчим хүч, шатахуун) сүүлийн хэдэн жилд уул уурхайн төслүүд нэмэгдсэнээр эрс өссөн.

*Дэлхийн зах зээлийн зэсийн үнэ 2008 оны 7 сард хамгийн дээд цэгтээ хүрснээс хойг 70% -р буурсан

**2011 онд том нүүрний компаугуд үйлдвэрдэж эхдэсэнээр дотоодын нүүрсний үнэнд 2011 онд бүтцийн өөрчлөлт гарсан (2011 оноос өмнө нүүрсний нэг тонд ноогдох үнэ 50 ам.д байсан бол дараа нь 100 ам.д болж өссөн)


***Нүүрсний болон зэсийн хил дээрхи үнэ 15% болон 13% тус тус 2011 оноос хойш буурсан

Хэдийгээр уул уурхайн салбарт хөдөлмөр их хэмжээгээр шаардахгүй боловч дундаж цалинд үзүүлэх нөлөө өндөртэй салбар юм


Өрх

Өрхүүдэд уул уурхайн салбарын нөлөөлөх нөлөө

Ажилчдын тоо (сая хүнээр)



Сарын дундаж цалин (сая төгрөгөөр)



2011 онтой харьцуулахад төрийн албаны дундаж цалин ~60% өссөн (эрүүл мэнд болон боловсролын салбарт хамгийн өндөр өсөлттэй). Уул уурхайн салбарын дундаж цалин хятадын эдийн засгийн бууралтаас шалтгаалж нүүрсний үнэ унасантай холбоотойгоор 2012 онд буурсан байна.

* Эрчим хүч, бөөний болон жижглэнгийн худалдаа, зочид буудал ба ресторан, санхүү даатгал, төрийн захиргаа ба боловсрол

Шинэ хуулийн төслийн ГХО-д нөлөөлөх хэмжээ ихэсч үйлдвэрлэл нь эхэлсэн уул уурхайн компаниуд зөвхөн үргэлжлүүлэн ажиллах ба бүх хайгуулын компаниуд үйл ажиллагаагаа зогсоох аюултай



Таамаглал : Уул уурхайн үйлдвэрлэлийн үнэ цэнэ (тэрбум доллар, 2007 оны үнээр), бүтээгдэхүүн ба төслийн төрлөөр

1


Уул уурхайн үйлдвэрлэл

2

Уул уурхайн үнэ

Одоогийн ашигт малтмалын тухай хуулийн хувилбар

Бүтээгдэхүүний төрлөөр



Төслийн төрлөөр




*Эрдэнэт, ОТ ил уурхай, ТТ Зүүн цанхи

**ОТ далд уурхай, ТТ баруун цанхи

Шинэ АМ-ын хууль бодлогын тодорхой бус орчинтой хувилбар

Бүтээгдэхүүний төрлөөр



Төслийн төрлөөр



Монголын хүрэн нүүрс 2012 оноос өмнө зөвхөн дотоодын хэрэглээнд зарцуулагддаг байсан (эрчим хүч) бөгөөд 2012 оны 11-р сараас эхлэн хүрэн нүүрсийг экспортлох болсон.

Эдийн засгийн үзүүлэлтүүд (их наяд төгрөг, 2013 оны үнээр)

	Одоо: 2012	2020 он гэхэд:	
		Одоогийн хууль хэвээр үлдвэл	Шинэ хуулийн төсөл хэрэгжвэл
Бодит ДНБ	15.7	38.9	28.2
Экспорт	6.0	21.2	8.4
Импорт	9.4	26.7	11.2
Бодит төгрөгийн ханш	1.0 (индекс)	1.1 (индекс)	0.7 (индекс)
Бодит цалин (худалдан авах чадвар)	1.0 (индекс)	2.5 (индекс)	1.8 (индекс)
Уул уурхайгаас орох татварын орлого	1.1	4.2	1.3
Нийт татварын орлого	4.7	11.7	8.3
Бодит ҮНБ	14.5	36.5	27.1

MINCGEM Mongolia v2 загварт эдийн засагийг 10 хэсэгт хуваадаг



1. Монгод	6. ОХУ
2. БНХАУ	7. Бусад евродын орнууд
3. Япон, Солонгос, Тайван	8. Хойд америк
4. Энэтхэг	9. Өмнөд америк
5. Азийн бусад орнууд	10. Ойрх дорнодын болон хойд Африкийн орнууд

MINCGEM Mongolia v2 загварт эдийн засаг бүр үйлдвэрлэлийн 20 салбарт хуваагддаг



1. Хүрэн нүүрс	11. Мал аж ахуй
2. Коксжих нүүрс	12. Загас агнуур ба ойн аж ахуй
3. Нефть	13. Боловсруулсан хүнс
4. Хий	14.Зэс цэвэршүүлэх, үйлдвэрлэх
5. Зэсийн хүдэр	15. Бусад боловсруулан аж үйлдвэр
6. Алт	16. Эрчим хүч
7. Бусад эрдэс бүтээгдэхүүн	17. Тээвэр
8. Кокс	18. Барилга
9. Цөмийн болон газрын тосны шатахуун	19. Төрийн захиргаа, батлан хамгаалал, эрүүл мэнд ба боловсрол
10. Үр тариа	20. Үйлчилгээ



Шинэ АМ-ын хуулийн нөлөөллийн тайлбар

- **Илүү өндөр эзэмшлийн хэмжээг шаардах** _ (1) Ашиглалтын лиценз эзэмшигчийн компанийн нийт хөрөнгийн 75%, 51% эсвэл 34% нь заавал Монголын иргэн байх
- **Бодит бус орон нутгийн оролцоог шаардах** _ (1) 60% хүртлэх худалдан авалтыг дотоодын аж үйлдвэрээс авах– одоогийн зах зээлийн чадамж хүрэлцэхгүй; (2) орон нутгаас хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигч нь хамтын болон бусад гэрээг байгуулах
- **Байгалийн нөөц баялгийг сорчлон олборлохыг хориглох** _ (1) ордыг эдийн засгийн үр ашгаас үл хамааран бүхэлд нь олборлохыг шаардах. Ингэсэн тохиолдолд уул уурхайн салбарт хөрөнгө оруулах боломжгүй болно. Уг тохиолдолд эдийн засгийн үр ашиг авчрах сорчлон олборлох доод талын хязгаарыг тогтоох шаардлагатай.
- **Хөрөнгө оруулах санхүүгийн боломжийг ихээр багасгах** _ (1) Орд ашиглах гэрээн зөвхөн стратегийн ордуудад л байгуулах боломжтой; (2) хаалтын үйл ажиллагааны зардлыг ажил гүйцэтгэх зөвшөөрөл авахын өмнө мөнгөн хэлбэрээр тусгай санд байршуулах шаардлага- капитал урсгалыг хаах (3) Роялтийн бүтэц улам нарийвчлах
- **Хөрөнгө оруулагчдад эзэмшлийн баталгааг багасгах** _ (1) Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын лиценз эзэмшигч хувьцааны тодорхой хувийг төр үнэ төлбөргүй эзэмших эрхтэй (хөөнгө оруулагч нь их хэмжээний хайгуулын зардал гаргасны дараагаар Засгийн газар тодорхойгүй хувийг өөртөө үнэгүй авах эрсдэлтэй)
- **Хайгуулын зардлын хамгийн доод хэмжээг маш өндөр байлгах** _ (1) Хайгуулын зардлын хамгийн доод хэмжээг маш өндөр байлгахгаар шаардах (US\$100 000). Монголын болон гадаад жижиг хайгуулын компаниуд энэ шаардлагыг биелүүлэх санхүүгийн чадамжгүй.
- **Лиценз олгох ил тод байдал сулрах** _ (1) тендерийн үйл ажиллагаа – авилгалд өртөх магадлал их. Тендерийг зогсоосон тохиолдолд , 4 хүртлэх жилээр тендерт орсон газрын лицензийг дахин олгохгүй